

*Б. Заяатай*

ИНЖИНАШИЙН «НЭГЭН ДАВХАР АСАР»,  
«УЛААНАА УЙЛАХ ТЭНХИМ» ГУНИГТ ЖҮЖИГ БОЛОХЫН УЧИР

«Нэгэн давхар асар», «Улаанаа уйлах тэнхим» бол Монгол үндэстний алдарт зохиолч, бодлоготон Инжинашийн төлөөлөх чанартай хоёр бүтээл болно. Өгүүлэлд, хоёр романд нарийн задлалт, нягт шинжлэлт хийж, «Нэгэн давхар асар», «Улаанаа уйлах тэнхим» нь Монгол үндэстний бичгийн зохиолын хамгийн анхны гунигт жүжгийн зохиол болохыг баталж түүний гунигт жүжгийн онцлог шинжийг хувь хүний янаг дурлал болон гэр бүлийн ашиг тусын зөрчлөөс болсон гунигт жүжиг, зүй зохист болон зүй зохистын хоорондох мөргөлдөөнөөс болсон гунигт жүжиг, хоёр зүйлийн хүчний хоорондох эвсэл ба тэмцлээс болсон гунигт жүжиг, горь хүсэл болон ёс муралын мөргөлдөөнөөс болсон гунигт жүжиг гэж дөрвөн талаас хайн шинжилсэн байна.

*Түлхүүр үг:* «Нэгэн давхар асар», «Улаанаа уйлах тэнхим», гунигт жүжиг, Инжинаш, монгол утга зохиол

*В. Jayatai*

ABOUT TWO WORKS OF INDJINASHI «ONE-STORED PAVILION»  
AND «THE CHAMBER OF RED TEARS»

Novels «One-stored pavilion» and «The Chamber of red tears» are the most significant works of Vanchinbalyn Indjinashi – a well-known Mongolian writer and politician of the XIXth century. A detailed analysis of these two novels allowed the author to attribute them to such a genre form as «the sad drama» - the first in the history of Mongolian literature. The events described in both works, the life peripeteia of the heroes, the universal antinomies, the contradictions between family values and personal aspirations are imbued with drama. According to the author of the article in «the Pavilion» and «the Chamber» dramatism dominates as a property of the human spirit, awakened by situations in which the cherished and the vitality remain for the heroes of these works unrealizable, of a pipe or being under threat. The connection of these works with the Chinese classic novel «The Dream in the red tower» is traced.

*Keywords:* Mongolian literature of the XIX century, Vanchinbalyn Indjinashi, the sad drama, «One-stored pavilion», «The Chamber of red tears», the Chinese literary tradition

Гунигт жүжиг бол өрнө дахины гоозүйн түүхэн дэх нэлээд боловсорсон гоо сайхны хэвшил болох юм. Тэр нь «түүхэн дээр харьцангуй тогтворжсон сонгодог байр суурийг олсон гоо сайхны хэвшил болох» [Wang Yichuan, 2011: 103] бөгөөд өнөөгийн дэлхий дээр ч хүчирхэг их амиллын хүчин бүхий сонгодог гоо таашаахуйн эх сурвалж болох юм. Гунигт жүжиг нь анх эхлэхдээ ший жүжгийн төрөл зүйл байснаа хожим нь харьцангуй тогтвортой гоо сайхны хэвшил болон бүрэлдэв. Иймэрхүү гоо сайхны хэвшил нь гүн зузаан хүний амьдралын утга агуулахуунтай байдаг. Жишээлбэл: «Эртний Грекийн үе дэх гунигт жүжиг голдуу хүн болон байгаль, хүн болон хувь заяа, хувь хүний сэтгэл болон улсын эрх ашигтай харилцан мөргөлдөх хүний амьдралын орон хязгаарыг үзүүлдэг байна» [Zhu li yuan, 2006 (a): 182]. Тэгэхээр гунигт жүжиг нь өрнөдахинд хөгжлөө ихэд олсон бөгөөд гунигт жүжгийн онол ч бас хөгжин улирсан байна. Яриангүй энд хэлж байгаа гунигт жүжиг бол урлаг доторх гоо сайхан болох юм. Харин амьдрал дундах гунигт жүжиг биш, амьдрал дундах гунигт жүжиг хүмүүст гоо таашаал өгөхгүй, урлаг доторх гунигт жүжиг нь хүмүүст гоо таашаал олгодог байна. Иймээс гунигт жүжгийн гоо сайхан гэдэг нь урлагийн гоо сайхан болох юм. Дундад улсад Зоу Шиүвэй Чиний «Улаан асрын зүүдэн» бол хамгийн анхны мэндэлсэн туужсын жүжгийн гунигт жүжиг мөн гэж хэлэгддэг бөгөөд хамгийн анх Ван Хөвө Вэйс гунигт жүжгийн ухагдахууныг хэрэглэн энэ романыг «гунигт жүжгийн доторх гунигт жүжиг» гэж үнэлсэн байдаг. Гэхдээ Хятадын гунигт жүжиг бол энэ үед сая бий болсон биш үүнээс нэлээд өмнө ший жүжгийн зохиолд илэрчихсэн юм. «Дундад улсын эртний гоо зүйд хэдийгээр гунигт жүжгийн ухагдахуунгүй боловч дундад улсын эртний сонгодог ший жүжигт их хэмжээний гунигт жүжгийн чанартай зөрчлийг зураглан бүтээсэн» [Hu xue gang, 2003: 59] юм. Жишээлбэл: «Дэү Эйгийн хилс», «Зуу овогтын өнчин хөвгүүн» гэх зэрэг. Монгол үндэстэнд гунигт жүжиг бий болох боломж байсан ч нэлээд хожуу үед сая бий болсон юм. Хэдийгээр эртний баатарлаг туульсад зарим агшин зуурын гунигт учрал, зарим шүлэг зохиолд гунигт ухамсар илэрч байсан ч жинхэнэ гунигт жүжгийн хэвшил болон илэрсэн нь хааш л Инжинашийн туужсын зохиолд билээ. Өөрөөр хэлбэл, Ижинашийн «асар», «тэнхим» хоёр роман нь Монгол үндэстний

жинхэнэ гунигт жүжгийн эхлэл болсон байна. Зарим судлаачаас Инжинашийн «асар», «тэнхим»-ийг «Улаан асрын зүүдэн»-тэй харьцуулан судлахдаа, тэр нь хурц ширүүн мөргөлдөөн дутагдаж зохиолын баатар нь үхэлд хүрсэнгүй, хүнд нүсэр гамшиг зовлон амссангүй тул жинхэнэ утга агуулга дээрх гунигт жүжиг болж чадсангүй, гунигийн хэмжээ нь тийм өндөр биш» [Zhang Yun, 2011: 88] гэж дурдсан байдаг. Харин «Улаан асрын зүүдэн»-д бол Лин Дай Иүй үхэж Жиа овогтын гэр бүл доройтож, Жиа Боу Иүй гэрээс гарсан, олон сайхан хүүхэн үхэх нь үхэж тун харамсалтай хувь заяанд учирснаар гарцаагүй гунигт жүжиг мөн, гунигт жүжгийн доторх гунигт жүжиг мөн гэж харьцуулан ярьж байлаа.

Инжинашийн «Асар»-т зохиолын баатар Фү Иүй, Су Жиеэ Дүгийн охин Су Жийтэй хуримласнаас Фү Иүй болон Чин Мүве, Шен Жү, Лу Мэй нарын гал халуун янаг хоостож, хоногийн болжмор шиг зүг зүгтээ сарнин одсон ба Су Жийгийн үхсэнээс болж Фү Иүй ертөнцөөс уйдаж, гэрээс гарах санаа агуулсныг зураглан бичсэнээр, хүмүүс үүнийг гунигт жүжиг болгон үзэж, харин хойно зохиогдсон «Улаанаа уйлах тэнхим»-ийг баярт жүжгээр үзсэн билээ. Иймээс зарим хүмүүс хэрэв «асар»- аар төгсгөсөн бол жинхэнэ гунигт жүжиг болж нэн их урлагийн нөлөөлөх хүчинтэй, харин «тэнхим»-ийг залган бичиж баярт төгсгөлтэй болгосон нь гунигт жүжгийн урлагийн амжилтанд нөлөөлөв гэж үзсэн ба бас зарим нь «асар»-ын тус биеийн гунигт жүжгийн гунигийн хэмжээ нь өндөр биш, жинхэнэ гунигт жүжиг биш гэж үзэж байлаа. Миний үзэхээр тийм бус «асар», «тэнхим» бол «Улаан асрын зүүдэн»-тэй адил бус онцлогтой гунигт жүжиг болох юм. Энэ ялгаа нь адил бус үндэстний хоорондох гунигт жүжгийн тохируулалт, адил бус хүсэл хөөцөлдөлд байх юм. Фү Иүйгийн хөөцөлдөл бол говийн өмнөх Монголчуудын хувь заяагаа өөрчлөх, эрдэм номыг эрхэмлэх оюун санааны идэвхтэй хөөцөлдөл болох бөгөөд зохиолч Инжинашийн хүсэл хөөцөлдлийн дотоод сэтгэлийг илэрхийлж байгаа юм. Тэр нь Зоу Шиүвэй Чиний бийр доорх Жиа Боу Иүйгээс эрс ондоо хүсэл хөөцөлдөл ба эрдэм ухааны боловсролтой хүн юм. Өгүүлэлд, «асар», «тэнхим» хоёр роман бол нэгэн зүйлийн өвөрмөц онцлог бүхий гунигт жүжиг болохыг нотлох болно.

## 1. Хувь хүний янаг дурлал болон гэр бүлийн ашиг тусын зөрчлөөс болсон гунигт жүжиг

«Асар», «Тэнхим»-д илэрсэн гунигт жүжгийн шинжийг шинжилбэл, тэр нь юуны өмнө голдуу хувь хүний янаг дурлал болон гэр бүлийн ашиг тусын хоорондох зөрчил мөргөлдөөнөөс болсон гунигт жүжиг болох юм. Гунигт жүжиг бий болох үндэс шалтгаан олон зүйл байдаг. Жишээлбэл эртнээс тогтоосон хувь заяаны тохируулалтын эрхээр бий болох, хувь хүний зан чанарын эмзгээс болох, хувь хүн болон нийгэм ёс суртахуунтай харгалдсанаас болох, хувь хүн болон гэр бүлийн зөрчил, хоёр зүйлийн ашиг тусыг төлөөлөх бүлэглэл хүчний хоорондох зөрчил хоёр анги давхаргын мөргөлдөөн, адил бус үзэл ухамсар ба түүнийг баримтлагчийн зөрчил мөргөлдөөн, хүн болон байгалийн мөргөлдөөн гэх мэт олон зүйлийн шалтгаан байлдаг. Фү Иүй хийгээд Чин Мүве, Шен Жү, Лу Мэй нарын гунигт учралыг ажиглавал, тэр нь хувь хүний янаг дурлал болон Бэй Хэү Фүгийн болон Чин Мүве, Шен Жү, Лу Мэй нарын гэр бүлийн ашиг сонирхлын мөргөлдөөнөөс болсон байна.

Фү Иүй болон Чин Мүве, Лу Мэй нарын янаг хайр бол сэтгэлийг мэдэгчийг хөөцөлдөгч янаг хайр, оюун санааны хайрыг хүсэгч чөлөөт янаг хайр болох юм. Энэ нь даруй хайр дурлал доторх хамгийн өндөр зарчим байж «биеч цогц өөрийгөө нөгөө нэг адил бус хүйст бодгаль цогцод шидэн өгч өөрийн биеэ даасан үзэл ухамсар болон онц зарим ганцаардмал өөрийн гэсэн оршихуйгаа тэвчин орхиод өөрөө эсрэг талынхаа үзэл ухасар дотор сая өөрийгөө олох танилт болно» [Hei ge er, 1979: 326]. Сэтгэлийг мэдэгчийн янаг хайр бол ийм хайр болно. Энэ нь нэгэн зүлийн романтик маягийн хайр юм. Энд Фү Иүй нар эсрэг этгээддээ сэтгэлийг мэдэгч гэж мэдрэгдсэн бөгөөд бүр өөрийн зарим онцгой ганцаардмал зүйлсээ тэвчиж чадах чинээгээр эсрэг талынхаа санаа сэтгэлд нийцүүлэхээр чармайсан юм. Иймэрхүү хайр дурлал дотор «үнэний нэгэн зүйлийн эрхэм дээд мурал чанар буй. Учир нь тэр нь зөвхөн горь тачаал дээр зогссон биш, өөрийн биеийн нэгэн зүйлийн элбэг баялаг, эрхэм дээд яруу сайхан оюун сэтгэлийг илэрхийлж байгаа юм» [Мөн тэнд, 332]. Гегелийн үзэхээр, иймэрхүү романтик хайр дурлал нь бас зарим талын ганцаардмал талтай, «агуулгын талаар өөрийн чөлөөт түгээмэл чанаргүй. Тэр нь зөвхөн онц зарим бодгаль цогцын хувь хүний сэтгэлгээ байж хүн

төрөлхтний оршин тогтнохуй дундах өнө мөнхийн дур сонирхол ба бусдач утга агуулахууныг багтаахгүй байдаг. Жишээлбэл, гэр бүл улс төрийн зорилго, эх улс, ажил төрөл, нийгмийн байр суурь гэх мэт» [Мөн тэнд, 332]. Иймэрхүү зүйлийн хайр нь бодит ахуй дотор амархан зөрчилтэй тулгардаг. Учир нь бусад зүйлийн дур сонирхол нь ч биеллээ олохоор хичээдэг.

Янаг хайртай мөргөлддөг нь яруу алдраас гадна улс төрийн дур сонирхол, гэр бүлийн хариуцлага гэх мэтийн өнө үүрдийн бодит цогцын шинжит хүчний тус бие байдаг бөгөөд зарим гадаад дахь онцгой байдал болно. Харин «асар», «тэнхим» дэх Фү Иүй нарын хайр дурлал бол голдуу хувь хүн болон гэр бүлийн үүрэг хариуцлагын бодит цогцын шинжит хүчинтэй мөргөлдсөн байна. Тэдний хайр сэтгэл гэнэтийн чанартай мөртлөө зайлшгүй чанартай юм. Тэдний хайр дурлал гунигт жүжиг болох нь харин зайлшгүй юм. Юунд гэнэтийн чанартай гэвэл, сэтгэлийг мэдэгчийг олох тиймэрхүү «заавал энэ нэг хүнд л сайн байх» янаг хайрыг олох гэгч амаргүй бөгөөд хэзээ хаана тааралдах нь болзошгүй, эрэгтэй эмэгтэй хоёр учирснаар сэтгэлийг мэдэгч болох бололцоо бас тун багаас болсон юм. Хайр дурлалын зайлшгүйчанар гэдэг нь тухайн цаг үед иймэрхүү өндөр боловсролтой хээнцэр сайхан хүмүүс тун цөөн, мөн иймэрхүү цөөн хүмүүсийг Бэй Хэу Фүд цуглуулсан бөгөөд энэ ордонд бас хүний ганц хөвгүүн эрдэм ухааныг хөөцөлддөг Фү Иүй байснаас болсон юм. Хэрэв энэ ордонд бас нэг хөвгүүн байсан бол хэрэг учрын зангилаа ондоо болж магад. Үүний зэрэгцээгээр тэдний янаг хайр гунигт жүжгийн шинжтэй болох нь зайлшгүй болно. Учир нь Шен Жү, Чин Мүве, Лу Мэй гурван сайхан хүн бүгд Бэй Хэу Фүд ирсэн нь тэдний ар талд нуугдаж байгаа гэр бүлийн ашиг харах зорилгоос болсон юм. Тухайлбал бүр Фү Иүйтэй ураг холбож ургийн барилдлага үүсгэх далд зорилготой. Энэхүү зорилгыг шууд дурдсангүй ч өрнөлд оршиж буй хэрэг болох юм. Иймэрхүү байдалд Фү Иүй энэ гурвын аль нэгийг сонгоход хүрвэл нөгөө хоёрт нь авч хэлбэл, гунигийн шинжтэй болох юм.

Бодит хайр сэтгэл үүссэн явцаас үзвэл, Фү Иүй үнэндээ Лу Мэй болон Чин Мүвед бүр хайртай болж сэтгэлийг мэдэгч гэж үзэж байжээ. Энэ хоёрын хэнтэй ч хуримласан ч болох байжээ. Гэвч тэр заавал нэгийг л сонгох ёстой тул тэдний хайр сэтгэлд заавал аль нэг нь гунигт шинжтэй болох байжээ. Чин Мүвегийн «хараацай

хулснаа уйлах дуулал» нь энэхүү гунигт сэтгэл ба гунигт учралын харуулал болж байна. Тэр нь хүмүүсийг гуниглуулж, гүн гүнзгий харамсал ба бодлогошролд оруулах юм. Шен Жүд авч хэлбэл, түүний энд ирсэн анхны зорилго санаандаа хүрч чадсангүй нь бас л гунигт жүжиг болох юм. Иймээс зарим утгаас авч хэлбэл, Фү Иүйгийн Сү Жийтэй хуримлах явдал гарсангүй нь ч гунигт шинж нэгэнтээ буй болсныг илтгэнэ. Яриангүй, энэ нь жинхэнэ гунигт жүжиг биш юм. Үүний дээр зохиолчоос алийг нь ч сонгосонгүй, энэ гурваас өөр нэгэн хүнийг сонгосон нь энэ гурвын зөрчлийг шийдвэрлэхийн зэргээр жинхэнэ гунигт жүжгийг бий болгожээ. Энэ нь даруй эрхэмдээд шинжтэй хайр дурлалыг эвдэж хаясан учир болно. Зөрчлийн шинж чанар нь хувираад хувь хүний хайр дурлал болон гэр бүлийн ашиг тусын хоорондох зөрчил мөргөлдөөн болон хувирснаас гунигт шинж нь нэмэгдсэн юм.

Нөгөө талаар иймэрхүү хувь биеийн хайр дурлал ба гэр бүлийн ашиг тусын мөргөлдөөн нь зайлшгүй үүсэх юм байна. «Асар», «тэнхим»-д ноёд хэргэмтдээс Фү Иүйд гурван удаа хүүхнээ өгөх гэсэн ургийн учир дурдсаныг өгүүлье.

Нэгдүгээрт нь, Фен Мин Жэүд болсон сүмийн хурал дээр Фү Иүй аавыгаа дагаж очоод олон ноёдын өмнө эрдэм чадвараа гайхуулснаас нэгэн өтгөс Жеүгийн ноёнд тоогдсон байна. Тэр Жеүгийн ноён охиноо Фү Иүйд өгөх санаа цухуйлгахад Фү Иүй хирдхийн Бэй Хэүг хүлээн авахаас айсанд, Бэй Хэү «бус тийш хандаж өөр хүн лүгээ энэ тэрийг хэлэлцэж» [Инжинаш, 2010: 157] аргацаан өнгөрүүлснээс энэхүү ургийн учир бүтсэнгүй. Энд Бэй Хэү ургийн учрыг зөвшөөрсөнгүй нь Фү Иүй нарын янаг хайрыг хүндэтгэн үзсэнээс болсон биш харин тэр Жеүгийн ноён бол тийм их ноён биш бөгөөд тэдэнд улс төрийн талын их түшиг болж чадахгүйгээс болсон юм. Хоёрдугаарт нь, төрийн хүндэт сайд Дүн Бэй Жиюүн мужийн Байла Су Ан, Су Жиеэ Дү хүүхнээ Фү Иүйд өгөх гэхэд Бэй Хэү дороо зөвшөөрөв. Су Жиеэ Дү бол тухайн дээд түшмэл болох бөгөөд түүний бат түшиг болж болох тул түүнтэй ураг бололцсоноор түүний үүд өрх Фү Иүйгийн хожим ирээдүй улам сайн болох бололцоотойгоос болсон юм. Энэ бол нэгэн зүйлийн гэр өрхийн ашиг тусын төлөөх ашиг харах ураг мөн. Иймэрхүү эрх ашиг болон Фү Иүй нарын хувийн янаг хайртай мөргөлдөх үес хувийн ашиг тус сүйтгэгдэж гунигт жүжиг үүссэн байна. Гуравдугаарт нь, Фү Иүй аавыгаа дагаж нийслэл хотод

орсны хойно төрийн их сайд Дай Жүн Тан, Дай Шин Мин охиноо өгөх гэж зууч явуулсныг Фү Иүй үг дуугарсангүй эсэргүүцсэн бөгөөд Бэй Хэу албадсангүй тул орхиж хаяв. Энд Бэй Хэу, Фү Иүйг албадан ургийн хэргийг хүлээн эс авсан нь өмнө нь түүний толгой мэдсэнээс болж Фү Иүйгийн гуниг зовлонг бий болгосон гэмшил байгаа бөгөөд энэ Дай Жүн Тан өмнөд орны ноён бөгөөд тэдэнтэй шууд захирагдах харьцаагүй болсон юм. Үүнээс үзэхэд Фү Иүйд ноёдын охин өгөх явдал эрт оройгүй үүсэх тул түүний хайр дурлал нь зайлшгүй гунигт учралтай учрах болно. Учир нь энд Фү Иүй нарын хайр дурлал бол эрхэм дээд шинжтэй бөгөөд эрх чөлөө болон идэвхтэй үнэ өртгийг төлөөлж байгаа тул иймэрхүү үнэ өртөгтэй зүйлс сүйтгэгдэх үед гунигт жүжиг бий болдог юм. Энэхүү шийдэл бол хүнд ноцтой юм. Энэ нь Фү Иүйгийн аливаа хүсэл, аливаа сайн сайхан хүслийг шийтгэн эвдсэнээр үл барам, Лу Мэй нарын янаг хайрыг хайр найргүй уран тэмтэгчиж хаяжээ. Зарим утгаас авч хэлбэл, Фү Иүй нарын хувийн хайр дурлалын бий болсон нь эхэлмэгцээ даруй гунигт жүжиг бий болох үндэс суурийг тавьж өгчээ. Учир нь тэрхүү цаг үеийн түгээмэл жам, хууль ёс суртахууны орчин тойрон доторх зайлшгүй чанар нь чөлөөт янагийг агшин хоромд сүйтгэхич хүчин чадалтай юм. Үүнээс үзэхэд Фү Иүй нарын үнэн хайр болон гэр бүлийн ашиг тусын гунигт шинжийн зөрчил мөргөлдөөн нь даруй «эрх чөлөө болон зайлшгүй хувьсангуй харьцаа мөн» [Вie li ya ye fu, 1993: 26]. Энд хэлж байгаа эрх чөлөө гэдэг нь даруй Фү Иүй нарын чөлөөт хайр дурлалын хөөцөлдөл ба сэтгэлийг мэдэгчийг олох хүслэнгийн сайхан мөн. Зайлшгүй гэдэг нь иймэрхүү хүслэнгийн сайхан ба хөөцөлдлийн зайлшгүй тулгарах саад ба зөрчил мөргөлдөөн болох юм. Энэ нь бас хайр дурлалын түүхийн зайлшгүй шаардлага ба бодитоор биелүүлж дийлэхгүйн хоорондох зөрчлийг хэлж байна.

«Асар», «Тэнхим»-ийг үзвэл, Фү Иүйгийн янаг хайрын гунигт жүжиг нь гэнэтийн шиг юм. Энэ нь Чин Мүве янагийн өрсөлдөөнөөс ухран гарч «хараацай хулсанд уйлах дуулал»-ыг бичсэний дараа үүсчээ. Хэдийгээр Чин Мүвед авч хэлбэл энэ нь туйлын их гуниг зовлон болох боловч Фү Иүйд авч хэлбэл арай тийм их гуниг биш юм. Гэхдээ яг энэ үед Су Жиеэ Дү илэрснээр аливаа бүхнийг бүр өөрчилсөн байдаг. Иймээс зарим хүмүүс

«Хэрэв (энэ хүн буюу тэр хүн анх эхэндээ тэгж бодсонгүй, тэгж хийсэнгүй) гэж бодол хийлэх үес нэгэн зүйлийн догдлол буюу таамаглал урган гардаг» [Liu xiao feng xuan bian, 2009: 67]. Өөрөөр хэлбэл, Фү Иүйг хэрэв Су Жиеэ Дүд учруулсангүй бол гэх таамаглал байж болох бөгөөд энэхүү гунигт жүжгийн үүсэл нь гэнэтийн шиг санагдуулах боловч тэр нь үнэндээ гэнэтийн биш зайлшгүй зүй зохистой тохируулал болох юм. Учир нь том их хурал цуглаан болох бүр Бэй Хэу заавал Фү Иүйгээ дагуулан оролцдог. Учир нь түүний сэтгэлд үрийн ганц хөвгүүн Фү Иүйгээ хүн олны өмнө таниулж хожим ирээдүйн үйлс амьдрал, үүд өрхөө гэрэлтүүлэх хүсэл дагалдаж байдаг. Иймд Су Жиеэ Дү шиг том сайд ноёнттой уулзах нь түүний хүсэл болох бөгөөд гэр бүлийн ашиг тусын төлөөлөгч болох тул том ноёдтой уулзах нь зайлшгүй учир болох юм. Үүний дээр Фү Иүйг өнгө зүс, эрдэм авьяас зэргээрээ хүний сайшаал магтаалыг олдог. «Гэдэг учрын үүссэн шалтгаан нь ямар онцгой болсон ч иймэрхүү ертөнцийн бүтэц нь тасралтгүй (тохиолыг сэмээр хүлээн), өөрийн биеэсээ шинэ (иймэрхүү маяг)-ийн хэрэг учрыг үүсгэн гаргахаар бэлтгэдэг. Иймээс гунигт жүжиглэг шинжит хэрэг учир нь даруй түүний нөгөө нэгэн мөн чанарын онцлог болох (зайлшгүй чанар)-тай болдог» [Liu xiao feng xuan bian, 2006: 66]. Үүнээс бид Фү Иүйгийн янаг хайрын гунигт жүжгийн зайлшгүй чанарыг ойлгож болно.

«Тэнхим»-д илэрсэн Чин Мүве, Лу Мэй нарын хувь заяагаа эсэргүүцсэн эсэргүүцэл тэмцэл нь бас тэдний эрх чөлөөт янагийн сэтгэл ба зорилго, гэр бүлийн ёс суртахуун, ашиг тусын мөргөлдөөний үр дүн болох юм. Энэ хоёр зөрчлийн үр дүнд, Лу Мэй болон Чин Мүве нар муухай хүргэнд мордох болж, муу заяатай учрах болсон байдаг. Энэ нь тэдэнд авч хэлбэл давхар гуниг болжээ. Фү Иүйг алдсан хүнд гунигийн дээр бас муухай үзэмжтэй хүргэнд мордох болсон нь хүнд их гуниглалт шинжийг нэмэгдүүлжээ. Иймэрхүү гунигт жүжгийн шинж нь «урлаг дотор нөхөж дийлшгүй хохирлын тухай нэгэн гунигт дууг илрүүлэхийн зэргээр бас хүний баларшгүй мөнхийн баяр баясгалангийн магтаал дууг илрүүлдэг байна» [Bie li ya ye fu, 1993: 27] байна. Энд зохиолын баатрын янаг хайрын шийдэл нь нөхөж дийлшгүй хохирлыг бий болгосон юм. Гэхдээ тэр нь зохиолч Инжинашийн төдий биш тэр цаг үе ба түүнээс хойших цаг үеийн олон хүний баларшгүй мөнхийн магтаал сайшаалыг олох нь лавтай. Иймээс



хувь хүний хайр дурлалын хүсэл сэтгэл болон гэр бүлийн ашиг тусын хоорондох мөргөлдөөнөөс болсон гунигт жүжиг нь «асар», «тэнхим» дэх гунигт жүжгийн хэвшлийн чухал нэгэн онцлог шинж нь болжээ.

## 2. Зүй зохист болон зүй зохистын хоорондох мөргөлдөөнөөс болсон гунигт жүжиг

Утга урлаг доторх гунигт жүжгийн мөргөлдөөний хоёр талын нэг тал нь сайн сайхан буюу үнэн ёсыг төлөөлж, нөгөө тал нь муу муухай, гаж бурууг төлөөлөн мөргөлдөх үзэгдэл олон байдаг ч зарим үед заавал ийм биш харин хоёр тал нь бүр зүй зохистой байдаг байдал илэрнэ. Энэ нь гунигт жүжгийн бас нэгэн зүйлийн оршихуй мөн. Гегель иймэрхүү зүйлийн гунигт жүжгийг эрхэмлэн сайшааж, сайн гунигт жүжиг гэж үздэг. Түүний үзэхээр «гунигт жүжиг зөвхөн цол сайн буюу цол мууг илрүүлж болохгүй, сайн гунигт жүжгийн мөргөлдөөний хоёр тал нь бүр сайн байвал зохино. Үүний зэргээр бас сайны харалтыг хөөцөлдөх явц дунд муу явдал хийлгэх болгоно» [Zhu li yuan, 2006 (б): 164]. «Асар», «тэнхим»-д илэрсэн гунигт жүжгийн хэвшлийг ажиглавал, Фү Иүйгийн хайр дурлал болон түүний аавын толгой мэдэж Су Жиеэ Дүгийн охиныг гэрлүүлсэн явдал нь нэгэн зүйлийн зүй зохист шинж болон нөгөө нэг зүйлийн зүй зохист шинжийн зөрчил болно. Юуны өмнө Фү Иүйгийн хайр дурлал бол сэтгэлийг мэдэгчийн эрхэм нандин хайр дурлалын хөөцөлдөл болох тул гагцхүү тэрхүү цаг үе бус одоо ирээдүйд ч гэсэн үнэ цэнтэй эрхэм дээд хөөцөлдөл мөн. Энэ бол хүний нийгмийн эрхэм дээд хүсэл болох юм. Иймээс тэр нь зүй зохистой байдаг. Энэ нь урлаг дотор илрэхдээ, олон хүний бахархал ба дэмжлэгийг олдог нэгэн зүйлийн гоо сайхан болж байна.

Фү Иүйгийн Лу Мэйн сэтгэлийг олохын төлөөх зовлон шаналал, арга самбаа, үйл хөдлөл, хараацайн сүүлд уясан шүлэг, Лу Мэйн хариу бичсэн шүлэг, Лу Мэйн өвдсөн ба туурвисан хавар цагийн мөрөөдлийн шүлэг, Фү Иүйгийн Лу Мэйд өгсөн хайрын илэрхийлийн захидал зэрэг нь бүр ертөнцийн доторх сэтгэлийг мэдэгч хүмүүсийн цол цэвэр, ясанд ором гүн гүнзгий хайр сэтгэлийг харуулж хүний ертөнцийн жинхэнэ үнэн хайр сэтгэлийг мэдрүүлж байдаг. Энэ бол жинхэнэ янаг хайр мөн, энэ бол зүй

зохист хайр юм. Фү Иүй болон Чин Мүвегийн хайр сэтгэлээр авч хэлсэн ч, Фү Иүйгийн Чин Мүвег бишрэн тоож сэтгэлийг мэдэгч гэж үзэх болсон Чин Мүвегийн өнгө зүс, хэтийдсэн эрдэм мэдлэг, цэцэн сэргэлэн зан, хүний сэтгэлийг тааж мэдэх ухаан мэдлэг зэрэг нь Фү Иүйгийн сэтгэлийг ихээр татаж салахын аргагүй хайр сэтгэлтэй болгосон юм. Энэ нь мөн жинхэнэ хайр дурлал болно. Чин Мүвегийн «хараацай хулснаа уйлах дуулал» нь нэгэн анги хүний ертөнцийн тасархай дуулал болж, үнэн хайр сэтгэл үхтэл мартахгүй өнө мөнхийн хайрын хүчийг таниулсан юм. Иймээс Фү Иүй болон Чин Мүвегийн янагийн сэтгэлийг хүмүүс бас зөвшөөрөн таалж өрөвдөн хөөрхийлдөг. Иймээс тэдний янаг хайр нь зүй зохистой байдаг.

Гэхдээ зөрчил мөргөлдөөний нөгөө тал болох Фү Иүйгийн аав Бэй Хэүгийн төлөөлсөн ашиг тус буюу санаа бодол нь бас зарим утга дээрээ зүй зохистой байдаг. Түүнийг зүй зохисгүй гэж хэлж болохгүй. Нэгэн сурвалжит айл өрхийн эрх сүрт ахлагч болсны хувьд, үүд өрхөө гэрэлтүүлэх, үрийн ганц хүүгээ эрдэм номтой болгон хүмүүжүүлэхийн төлөө зүтгэх, олон ноёд сайдад танигдаж тохиол олон хишиг хүртэх, бат түшиг болж чадах ураг олох зэрэг нь бас зүй зохистой байдаг. Дахиад хэлбэл, «асар», «тэнхим»-д туссанаар Фү Иүйгийн эцэг Бэй Хэү бол ахмад настнаа хүндэтгэж, төрөл саднаа халамжилдаг, үр хүүхдээ эрдэм ном ёс сурталтай болгон хүмүүжүүлэхийг хичээж эрдэмтэн мэргэдийг хүсэн хайрладаг, үгээгүй ардыг ч зохих хэмжээгээр өрөвдөн асарч улс төрийн талаар ч зохих хүслэнтэй энэрэнгүй хичээнгүй хүн юм. Хэдийгээр тэр феодалын ёс суртахууны ёсоор хүүхдэдээ онцгой чанга, хүүхдийн өмнө ихэрхэг овлодог, жаахан өнгөнцөр хуурмаг, Ше Тияан Женийг ов мэх хэрэглэн ордондоо авчирсан зэрэг гэм байх боловч ерөнхийдөө сайн хүний дүр болно. Энэ нь «Улаан асрын зүүдэн» дэх Жиа Жентэй адилтгавал хол гэгээн мэргэн өршөөлтэй байна. Иймээс Бэй Хэү бол «муу», «муухай»-д багтах дүр биш. Мөн ч нэгэн феодалын эзэн эрхт нийгмийн эрийн эрхийн төлөөлөгч болсны хувьд, үүд өрхөө гэрэлтүүлэхийн төлөө хөвгүүндээ том сайд ноёны охиныг ураглуулж, ураг барилдах ташрамд өөрийн гэр угсаагаа дэгжрүүлэх хүсэл зорилго нь тухайн феодалын цаг үедээ зохих зүй ёс юм. Үүнийг тас буруу гэж хэлэхэд бэрх. Ихэд ноёдтой ураглахаар дамжин үүд өрхөө дэгжрүүлэх хүсэл зохиолч Инжинашийн багын үед байсныг судлаачид нэгэнтээ гэрчилсэн юм. Өдөр ирэхүйеэ доройтож байгаа

том сурвалжит гэр бүл болсны хувьд, Ванчинбалын дараах хүүхдийн бие дээр том их дараас буюу хэцүү үүрэг тулгарч байв. Энэ нь даруй ихэс ноёдын дэмжлэгээр өндөр байр суурь олж үүд өрхөө гэрэлтүүлж, бүх гэр аймгаа сайхан амьдруулах болно. Иймээс бага насны үе дэх Инжинаш Харчин вангийн ордонд очиж вангийн хүргэн болохыг хичээж байсан түүх нь мөн түүний гэр өрхөө дэгжрүүлэх гэсэн бодол хүслийнх нь гэрч болж байна. Учир нь Инжинашийн өвөө, аавын үед бүр Урианхай овгийн ноёдтой ураг барилдахаар дамжиж, хошууны туслагч тайж мэтийн чухал тушаал олж, гэр угсаагаа тэжээж амьдарч байсан юм. «Асар», «Тэнхим» дэх Бэй Хэүгийн дүрд ч иймэрхүү хүсэл тусгалаа олжээ. Иймээс Бэй Хэүгийн хүсэл ба зорилгод зохих хэмжээний зүй зохистой шинжтэй байна. Яг иймэрхүү зүй зохист хоёр хүчин буюу 2 талын мөргөлдөөн нь гунигт жүжгийг бий болгосон байна.

Гегелийн хэлснээр, гунигт жүжгийн мөргөлдөгч хоёр тал нь бүр өөр өөрийн зүй зохист шинж ба өрөөсгөл шинжтэй. Фү Иүйгээр авч хэлбэл, сэтгэлийг мэдэгчийн хайр дурлалыг хөөцөлдсөн нь зүй зохистой боловч гэр өрхийн ашиг талыг эс бодолхийлсэн өрөөсгөл талтай, Бэй Хэүгээр авч хэлбэл, тэр гэр өрхөө дэгжрүүлэх хүсэл зорилго нь зүй зохистой боловч бас хөвгүүнийхээ сайн сайхан янаг хайрыг сүйтгэсэн өрөөсгөл чанартай. Яг иймэрхүү «хүчний хоёр талд бүр зохих хэмжээний зөв ёсч чанар ба зүй зохист чанарыг агуулсан байдал доор үүссэн мөргөлдөөн нь сая гунигт жүжгийн ирэлт мөн байна» [Zhang fa, Wan xiao hu, 2005: 147]. Энэ нь нэг тал нь сайн сайхан, зүй ёстой ба нөгөө тал нь муу харгис хүчин болох мөргөлдөөнөөс болсон гунигт жүжгээс бас их гунигийн шинжтэй. Энэ бол аргацаагүй байдал дор гуниг болох юм. Энд «хэн нь ч (зүй ёс)-той байж тэмцэлд орсон зохиолын баатар бүр, ямар нэгэн хүчин бүхэн адилхан эрхэм дээд эрхийг төлөөлж байна. Эсвэл бүр адилхан эрхэм дээд үүрэг хариуцлагыг үүрч байх буюу гүйцэтгэж байдаг» [Liu xiao feng xuan bian, 2006: 63]. Иймэрхүү байдалд янаг хайраа алдаж гунигт учралтай болсон Фү Иүй аавдаа гомдохын аргагүй, Лу Мэй нар ч яахын аргагүй хувь заяандаа гомдож санаа алдах л хэрэг. Гэвч гунигт жүжиг гарцаагүй үүссэн байна. Учир нь үнэ өртөгтэй зүйлс энд сүйтгэгдсэн байна. Мөргөлдөөний хоёр тал нь «бүр нэлээд өндөр идэвхтэй өртгийн ачаалагч болох» [Мөн тэнд] тул хоёр талын хэн нь ялагдсан ч бүр гунигт жүжгийн

шинжтэй болно. Иймээс Инжинаш шиг өндөр боловсролтой зохиолчоос гунигт жүжгийн шинжийг илрүүлэхдээ «зөрчил тэмцлийн эргэлгэнд орсон аль нэгэн бүлгийн үнэ өртгийг нарийн тодорхой товойлгож, зохиолын баатрын дотоод дох эрх ашгийг нарийлаг бөгөөд тов тодорхой зураглах» [Мөн тэнд, 64] юм байна.

### 3. Хоёр зүйлийн хүчний хоорондох эвсэл ба тэмцлээс болсон гунигт жүжиг

Гунигт жүжиг бий болоход заавал зөрчил мөргөлдөөний хоёр тал байх хэрэгтэй, тэр нь сайн муугийн зөрчил, эсвэл хоёр зүй ёст чанарын хоорондох зөрчил, эсвэл хүслэн болон бодит ахуйн зөрчил ч гэсэн бүр л хоёр талын зөрчил мөргөлдөөн болох юм. Зөрчил мөргөлдөөн бол гунигт жүжгийн шинж бий болох чухал хүчин мөн. «Мөргөлдөөн бол гунигт жүжгийн шинж чанар мөн. Мөргөлдөөний мөн чанар бол хувь заяанаас түүний үрэгдэл бодис төгсөн нөхцөлгүй шаардлага болно» [Beilinsiji, 1963: 138]. Хувь заяань түүн дүг дуугүйгээр муу заяа өгөх нөхцөлгүй шаардлага болох юм. Үүнд муу хувь заяа бол гунигт жүжиг бүхэнд дүүрэн байх бөгөөд мөргөлдөөнтэй нягт холбоотой. Үүнд мөргөлдөөн нь ямар хэлбэрээр явагдах нь гунигт жүжгийн онцлог шинжийг тогтоодог. Гегелийн үзэхээр «Жинхэнэ гунигт жүжгийн шинжит мөргөлдөөнийг бол хоёр зүйлийн аргаар шийдвэрлэж болно. Нэг зүйл нь мөргөлдөөний хоёр тал нь бүр сөнөөлд учирна. Нөгөө нэг зүйл нь мөргөлдөөний хоёр талын нэг тал нь найр тавьж, уулын тэрхүү өрөөсгөл шаардлагаа тэвчиж, хоёр этгээд эвсэх болно» [Zhu li yuan, 2006 (6): 166].

Инжинашийн «Асар», «Тэнхим» дэх гунигт жүжгийг ажиглавал, хэдийгээр шинэ өртгийг ачаалж, эрхэмдээд шинжийг төлөөлж байгаа Фү Иүйгийн янаг хайр нь гэрийн ахмадын эзэн мэдэх суртал ба зорилготой мөргөлдөх үес, хурц ширүүн зөрчил мөргөлдөөн үүссэнгүй, харин эвслээр төгсдөг. Энэ бол тус гунигт жүжгийн бас нэгэн онцлог болно. Фү Иүй, Лу Мэй, Чин Мүве нартай үнэн сэтгэлээ ололцож жинхэнэ сэтгэлийг мэдэгчээ гэж үзэж байсан юм. Мөн ч Лу Мэй, Чин Мүвегийн хайр сэтгэлийг ойлгож байсан юм. Гэтэл Бэй Хэүгээс Су Жиеэгийн охиноо өгөх гэсэн ургийн учрыг хүлээн авах үед Фү Иүй эсэргүүцэж чадсангүй аялдан дагасан байна. Энэ бол нэгэн зүйлийн эвсэл мөн. Энэ

эвслээс болж түүний жинхэнэ хайр нь алдагдаж гай гамшиг болсон юм. Фү Иүйгийн эвсэл нь юунаас болсон бэ гэвэл, юуны өмнө зан чанарын дорой буурайгаас болов. Фү Иүй багаасаа Фү Жен болон Луу Тайтайн хайрыг хүртэж эрх дархтай, онцгой харгалзлалтай өссөнөөс зан ааш зөөлөн ээргүү байдаг. Үүний дээр эцэг Бэй Хэүгийн чанга хатуу сургаал дор жаахан эмээмтгий дорой зан чанартай болов. Иймээс тэр аавыгаа эсэргүүцэхийг байтугай бусад хүнтэй ч хэрэлдэж зөрчилдөх зангүй. Хоёрдугаарт, тухайн үеийн эцгийн эрхийн хүнд чухал байр сууриас болов. Бэй Хэү бол Бэй Хэү Фүгийн ордны захирагч байж феодалын эрэгтэйн эзэн эрхийн төлөөлөгч мөн. Тэр нь нэг гэрийн их бага учир, аж амьдрал хүүхэд садны аливаа үйл учрыг цөм хамаардаг эрхтэй. Иймээс Фү Иүйд авч хэлбэл, аавын зарлиг бол зөрчиж болшгүй хууль давж дийлшгүй даваа аж. Гуравт, Фү Иүйгийн тус биеийн янаг хайр нь тийм боловсронгуй болоогүй, хэдийгээр өөрийн янаг хайрыг хөөцөлддөггүй байсан боловч иймэрхүү хайр нь тийм гүн гүнзгий тов тодорхой болоогүй. Зарим хэмжээн дээр бүрэг байсантай холбоотой. Хожим нь гунигт жүжиг бий болсны дараа тэр сая янаг хайрыг нэн гүнзгий танин ухаарч, хэн бол хайр болох, хэрхэн нандигнаж хайрлавал зохих тухай гэмшлийн дунд ухааран мэдсэн байна. Иймээс тэр хайр дурлал нь эцгийн санаа бодол буюу эрх ашигтай зөрчилдөх үе дэвлэрч гунигт жүжгийг бий болгосон байна. Дөрөвт, Фү Иүйгийн далд ухамсар доторх гэр өрхөө дэгжрүүлэх хүсэл ба бүх гэр угсааны ашиг тусыг бодолхийлэн бүх талыг бодсон ухамсар бий. Хэдийгээр зохиолд Фү Иүйгийн ийм бодол сэтгэл байна гэж дүрслээгүй боловч түүний бодит үйл хөдлөлөөс үзэхэд, иймэрхүү далд ухамсар хадгалагдаж байх нь тодорхой. Тэр эцгийн захиасыг өчүүхэн ч зөрчсөнгүй, Су Жиеэ Дүгийн охинтой уулзсаны дараа даруй түүнд сэтгэлтэй болж хоёул үнэхээр хайр сэтгэлтэй болов. Иймээс Фү Иүйгийн бодол сэтгэл, үйл хөдлөл нь зарим хэмжээн дээр зөрчилтэй юм. Энэ нь мөн түүний гунигт жүжиг болох нэгэн үндэс шалтгаан болсон байна.

Фү Иүйгийн хайр дурлал болон Бэй Хэүгийн эцгийн эрхийн хоорондох зөрчил бол «Асар», «Тэнхим» дэх гунигт жүжгийн гол зөрчил болох юм. Үүнээс гадна Су Жийгийн Фү Иүйд өгсөн хайр болон үхэл ангижралын зөрчил дунд гунигт жүжиг давхарлаж, Су Жий үхэж, Фү Иүйгийн хайр хоосорсон билээ. Иймэрхүү төгсгөл нь «өнө үүрд хүний сэтгэл доторх хамгийн эрхэм үнэт хүсэл замхран насан туршийн зол жаргал алдагдуулж» [Zhu li yuan, 2006

(б): 138], үзэгчдийг ч тэсгэлгүй гуниглуулдаг нь зайлшгүй. Гэхдээ үзэгчдийн гуниглах нь ганц Фү Иүйгийн төлөө биш Чин Мүве, Лу Мэй нарын нандин хайр сэтгэлийн төлөө юм. Үүнээс гадна Шен Жүгийн өвчтэй хүргэнд мордсон Лу Мэй, Чин Мүвег муухай хүргэнд ураглуулахаар болсон зэрэг нь тэдний өөрийн биетэй тэнцэх сэтгэлийн хүнээ олох сайхан хайрын хүсэл болон гэрийн ахмадын эзэн мэдэх зөрчлийн дунд гунигт шинжийг нэмэгдүүлсэн байна. Гэхдээ энд тэдний зөрчил шийдвэрлэх арга нь эвсэл биш харин тэмцэл болсон байдаг. Иймээс «Асар», «Тэнхим»-д илэрсэн гунигт жүжгийн хэвшлийн товойм нэгэн онцлог бол зөрчил мөргөлдөөний хоёр талын эвсэл байх мөртлөө хоёр талын тэмцэл ч байдаг байна.

#### 4. Чин хүсэл болон ёс суртахууны мөргөлдөөнөөс болсон гунигт жүжиг

«Асар», «Тэнхим»-ийн гунигт жүжиг үүссэн шалтгааныг ажиглавал, чин хүсэл болон ёс суртахууны мөргөлдөөн нь түүний нэгэн чухал онцлог болно. Хүний ертөнцийн аливаа зөрчил бол чин хүслээс болдог. Иймээс тэр нь ер утга зохиолын дүрслэн бичигдэх сэдэв болдог. Жишээлбэл, эртний Энэтхэгийн утга зохиолын онолд, утга зохиолын өгүүлэгдэхүүн утга буюу агуулга сэдвийг ярихад ном, гэтэлгэх, эд, хүсэл дөрвөн өгүүлэгдэхүүн аймгийг дурддаг бөгөөд «үйлийн үрийн эрхээр болсон ном, гэтэлгэх, эд, хүсэл зэрэг дөрвөн аймаг нь утга зохиолыг татах хүчинтэй болгох мөнхийн сэдэв мөн» [Шу Лин, 2010: 170] болох аж. Үүний доторх хүсэл гэдэг нь даруй чин хүсэл гэж ойлгож болох боловч тэр нь эртний энэтхэг ба төвөд монгол лам эрдэмтдийн онол үзэлд ерөнхийдөө «сэрлийн таашаал», «тэнгэр хүний оронд төгс жаргалан эдлэх» [Мөн тэнд, 173] «тэнгэр хийгээд хүний хүсэл, хүслийн эрдмийг төгс эдлэх» [Мөн тэнд, 175]-ийг заадаг байна. Жаргал цэнгэл хөөцөлдөх хүний сонсох, үзэх, үнэрлэх, хүрэлцэхүй, амтлах сэрлийн таван эрхтний жаргал буюу хүслийн таван эрдмийг ханатал эдэлж төгс жаргал эдлэх иймэрхүү хөөцөлдөл нь урлаг дотор дүрслэгдэх гол зүйл болох бөгөөд зөрчил мөргөлдөөн үүсгэх түлхэх хүчин болж, тэр нь зарим үед гунигт жүжгийг бий болгодог. Гэхдээ олонхдоо ёс мууралтай зөрчилдөн мөргөлдөх үес гунигт жүжиг болдог. Тэр нь хэдийгээр жаргал цэнгэлийг хөөцөлдөж байвч ямар нэгэн идэвх өртөгтэй

зүйлсийг агуулснаар, өөрөөр хэлбэл хүний ертөнцийн янаг хайрын хүслэнгийн чиглэлийг харуулж байгаа тул ёс муралын харгайд ялагдвал даруй гунигт жүжиг үүсдэг. Фү Иүй нарын янаг хайрын хөөцөлдлийг мөн нэгэн зүйлийн зол жаргалын хөөцөлдлийн илрэл гэж хэлж болно. Тэр нь нэгэн зүйлийн горь хүсэл болсны хувьд, зарим үед их догшин байж, ёс суртахуунтай зөрчил мөргөлдөөн үүсэх болдог. Эрх чөлөө буюу бодгаль шинжтэй эсэргүүцэлддэг нь түгээмэл орших ёс суртахуун, дүрэмжил болно. Тэр нь тун хүчирхэг хүчин чадалтай байдаг. Уран зохиолд олонхдоо горь хүсэл нь ихсээд зохих хэмжээн дээрээ хүрэх үед түүнийг хориглох буюу сөнөөх ёс суртахууны хүчин гарч ирдэг. Фү Иүйд авч хэлбэл, янаг хайрын хөөцөлдөл бол горь хүсэл, эцгийн эзэн эрх бол ёс мурал болох юм. Энэ хоёр зүйл зөрчилдөх үед эцэг нь даруй нэгэн зүйлийн ёс суртахууны төлөөлөгч мөн байж, Фү Иүй бол горь хүслийн төлөөлөгч болов. Гэхэд энэхүү төгс жаргал эдлэх хүсэл хөөцөлдөл нь ёс муралын хүчинд дарагдаж нугаралд учирснаар, зохиолын баатрын гуниглалт шинжийг бий болгосноор үл барам сонирхогч уншигчдад ч гунигт сэтгэл төрүүлдэг болсон байна. Учир нь энэхүү горь хүсэл бол хэдийгээр жаргал цэнгэлийн хөөцөлдөл мөн боловч нэгэн зүйлийн урлаг шинжийг агуулсан хүн төрөлхтний сайн сайхан хүслэнгийн чиглэлийг төлөөлж байгаа юм. Иймээс энэ нь даруй «хүний сэтгэлийн аяндааны горь хүсэл ба ёс мурал, хариуцлагат сэтгэлийн буюу зөвхөн ялж дийлшгүй харш саадын хоорондох мөргөлдөөн тэмцэл болно» [Zhu li yuan, 2006 (б): 171-172].

Фройдын сэтгэц мэдрэлийн ухааны ёсоор авч хэлбэл, Фү Иүй нарын янаг хайрын гунигт жүжиг бол ур чадавхын чин хүсэл болон нийгмийн ёс суртахууны зөрчлөөс болсон буюу зохиолын баатрын тус бие дээрх ур чадавхын догдлол болон үүнийг дарах хэт бигийн догдлол гэх хоёр зүйлийн догдлолын зөрчлөөс болсон гунигт жүжиг болно. Фү Иүй нарын янаг хайрын хөөцөлдөл бол хүний сэтгэцийн гүн давхаргад нуугдаж байгаа эзгүй ухамсрын гадаад илрэл буюу өөр бигийн эзгүй ухамсраас үүссэн, ур чадавхын горь хүсэл болно. Энэ бол хүний аливаа хөдөлгөөний түлхэх хүчин болох бөгөөд том их үүдэн бүтээх хүчинтэй. Тэр нь ердөө баяр жаргалын зарчмаар үйл хөдөлгөөн хийдэг. Иймэрхүү чин хүсэл ба ур чадавхаасаа болж Фү Иүй нар амь насны халуун

урмас оргилж сайн сайхан хүслэнгийн дунд живж байсан юм. Иймээс тэр нь аяндаа зохих өртгийг бүрэлдүүлсэн юм. «Хэрвээ цовхчин хөдөлж байгаа өртөг бүхий амь насны халуун урмас дутагдвал гунигт жүжгийн гоо сайхны хэвшил буй болж чадахгүй. Учир нь амь насны халуун урмасаа алдсан гэхээр биед гунигт жүжгийн чанар хэмээн байхгүй. Өртөггүй амь насны халуун урмасаас бий болох нь гунигт жүжиглэг шинж биш» [Er rong ben, 2002: 35] юм. Үүний эсрэгээр ёс суртахуун нь иймэрхүү чин хүслийг хянаж, хязгаарлаж, хориглож, боох үүрэг чадавхтай. «Асар», «Тэнхим»-д Бэй Хэу болон Чин Мүве, Лу Мэйн гэрийн ахмад бол бүр иймэрхүү хүний сэтгэл санааны гүн доторх ёс муралын төлөөлөгч болох юм. Хүний дотоод сэтгэлийн гүн давхарга дахь ёс суртахууны хүчин бол туйлын хүчирхэг байж, тэр нь цаг ямагт хүний ур чадавхыг харж хардаж, дарж хориглодог. Фү Иүйн тус биед авч хэлбэл, түүний эцэг Бэй Хэу бол түүний эзгүй ухамсрын гүн дэх нийгмийн үүрэг, ёс муралын төлөөлөгч болох «хэт би» болж байхад түүний янаг хайрын хөөцөлдөл бол өөр бигийн догдлол болж байдаг. Энэ хэт би болон өөр бигийн зөрчил дунд, хүчирхэг их хүчинтэй хэт би нь өөр биг няц дарснаас тэр нь сэтгэц мэдрэлийн хямралд учирсан эмзэгт өөр би буюу гунигт шинжийн «өөр би» болсон байдаг. Үүнээс түүний ур чадавх буюу өөр бигийн догдлол нь дарагдаж ёс суртахууны хүчний догдлол болсон «хэт би» нь ялалт олсон байдаг. Ингээд үзвэл Фү Иүйн янаг хайр болон Бэй Хэу ёс муралын хүчний зөрчил бол зарим хэмжээн дээр авч хэлбэл Фү Иүйн өөрийн бие дээрх сэтгэл санааны тэмцэл болох юм. Энд «гуниг зовуурийг бий болгосон тэмцэл бол зохиолын гол баатрын сэтгэл санааны дотор явагдсан, адил бус догдлолын хоорондох тэмцэл болно. Энэхүү тэмцлийн үр дүн бол даруй түүний нэгэн зүйлийн догдлолын устал болно [Zhu li yuan, 2006 (б): 179]. Өөрөөр хэлбэл энд «өөр би»-ийн догдлол устаж «хэт би»-ийн догдлол ялалт олжээ. Энэ нь мөн чанар дээрээ нэгэнт чин хүсэл болон ёс суртахууны тэмцлээс болсон гунигт жүжиг болно. Энэ нь юунд уншигчдын сэтгэлд гунигт сэтгэлийг бий болгосон гэвэл Фү Иүйн жаргал цэнгэл хөөцөлдөх баяр баяслын зарчим нь маш олон уншигчдын дотоод сэтгэлд дарагдаж байсан далд ухамсрыг нь сэргээн тэдний горь хүслийг нь сэргээснээс болжээ. Өөрөөр хэлбэл Фү Иүй нарын янаг хайр нь олон хүмүүсийн дотоод сэтгэлгээний чин хүслийг төлөөлөн биелүүлсэн



байна. Иймэрхүү байдалд Фү Иүйгийн янаг хайрын нугарал бүдрэлд учирсан нь олон хүмүүст бас хүчтэй цохилт өгч тэднийг гуниглуулах болгосон юм. Энэ нь түүний гунигт жүжгийн шинжийг нэмэгдүүлсэн бас нэгэн чухал шалтгаан болж байна.

Багцлаад хэлбэл, «Асар», «Тэнхим» дэх гунигт жүжгийн хэвшил бол хувь хүн болон гэр бүлийн ашиг тусын зөрчил, зүй зохист болон зүй зохистын хоорондох зөрчил, хоёр зүйлийн хүчний эвсэл ба тэмцэл, чин хүсэл болон ёс суртахууны тэмцлээс болсон гунигт жүжгийн онцлогтой бөгөөд яг эдгээр онцлог нь этгээд онцгой гунигт жүжгийн хэвшлийг бүрэлдүүлж, нэн их гунигт шинжтэй болгосон юм.

### Номзүй

1. 别林斯基：《戏剧诗》，《古典文艺理论译丛》（第五册），人民文学出版社，1963年。

2. 别利亚耶夫：《美学辞典》，东方出版社，1993年。

3. 卮荣本：《文艺美学范畴研究：论悲剧与戏剧》，南京大学出版社，2002年。

4. 黑格尔：《美学》（第2卷），朱光潜译，商务印书馆，1979年第一版。

5. 胡雪冈：《曹雪芹的悲剧观》，《美学范畴新探》，中国文联出版社，2003年。

6. Инжинаш. Нэгэн давхар асар. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 2010.

7. 刘小枫选编：《德语诗学文选》（下），华东师范大学出版社，2006年9月第一版。

8. Шу Лин. Монголчуудын Төвөд хэлэн дээрх утга зохиолын онолын тогтолцоо / докторын зэрэг хамгаалсан өгүүлэл. Өвөр Монголын Их сургуулийн Монгол Судлалын Дээд сургууль, 2010 оны 6-р сар.

9. 王一川主编：《新编美学教程》（修订版），复旦大学出版社，2011年。

10. 张发、王晓旭主编：《美学原理》，中国人民大学出版社，2005年版。

11. 张云：《〈一层楼〉对〈红楼梦〉的因袭与再创造—以叙事模式为中心》，红楼梦学刊，2011年3期。

12. 朱立元主编（a）：《美学》（修订版），高等教育出版社，2006年7月第二版。

13. 朱立元主编 (6): 《西方美学范畴史》(第三卷), 山西教育出版社, 2006年。

### References

1. Beilinsiji. Xi ju shi / Gu dian wen yi li lun yi cong (di wu ce). Ren min wen xue chubanshe, 1963.
2. Bie li ya ye fu. Mei xue ci dian. Dong fang chubanshe, 1993.
3. Er rong ben. Wen yi mei xue fan chou yan jiu: lun bei ju yu xi ju. Nan jing da xue chubanshe, 2002.
4. Hei ge er. Mei xue / Zhu Guang qian yi. Shang wu yi shu guan, 1979.
5. Hu xue gang. Cao Xueqin de beiju guan // Meixue fanchou xin tan. Zhong guo wen lian chubanshe, 2003. 253 p.
6. Inzhinash. Negen davkhar asar. Uvur mongolyn ardyn khevelelin kho-roo, 2010.
7. Liu xiao feng xuan bian. De yu shi xue wen xuan (xia). Huadong shifan daxue chubanshe, 2006. № 9.
8. Shu Lin. Mongolchuudyn Tuvud khelen deerkh utga zokhiolyn onolyn togtoltsoo / doktoryn zereg khamgaalsan uguulel. Uvur Mongolyn Ikh surguuliin Mongol Sudlalyn Deed surguul', 2010 ony 6-r sar.
9. Wang Yichuan. Xinbian meixue jiaocheng / xiu ding ban. Fu dan da xue chubanshe, 2011.
10. Zhang Fa, Wan Xiao Xu. Mei xue yuan li. Zhong guo ren min da xue chubanshe, 2005.
11. Zhang Yun. «Yi ceng lou» dui «Hong lou meng» de yin xi yu zai chuangzao – yi xu shi moshi wei zhong xin // Hong lou meng xue kan. 2011. № 3.
12. Zhu li yuan. Mei xue / xiu ding ban. Gao deng jiao yu chubanshe, 2006 (a).
13. Zhu li yuan. Xi fang mei xue fan chou shi (di san juan). Shang xi jiao yu chubanshe, 2006 (6).